# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

*1992 оны 5 дугаар сарын 29-ний өдөр* *Улаанбаатар хот*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зорилго, үйл ажиллагааны үндсэн зарчим, чиг үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоон түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ хуулийн зорилт оршино.

**2 дугаар зүйл. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь /цаашид "Зөвлөл" гэх/ үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага мөн.

*/Энэ зүйлийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

**3 дугаар зүйл. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

1. Зөвлөл үйл ажиллагаандаа хууль дээдлэх, улс үндэснийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэн хамгаалах, эрх хэмжээнийхээ асуудлыг хамтран хэлэлцэж санал нэгтэйгээр шийдвэрлэх зарчмыг баримтална.

2. Зөвлөл нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэн явуулна.

3. Зөвлөл нь Улсын Их Хурлаас баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан ажлаа явуулна.

4. Зөвлөл ажлаа Улсын Их Хурлын өмнө хариуцна.

**4 дүгээр зүйл. Зөвлөлийн чиг үүрэг**

1. Зөвлөл нь дараахь асуудлаар үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагааг болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй:

*[/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/]*

1/ өөрийн орны улс төр, нийгмийн амьдралд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг бэхжүүлэх, Үндсэн хуулиар тодорхойлсон төр, нийгмийн байгууллыг бататгах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах;

*[/Энэ заалтыг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/]*

2/ Монгол Улсын үндэсний баялгийг зүй зохистой ашиглах, үндэсний технологийг хамгаалж орчин үеийн ололтоор баяжуулан хөгжүүлэх, дэлхийн аж ахуйн хэлхээ холбоонд идэвхтэй, уян хатан оролцох зэргээр эдийн засгаа дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бие даан хөгжих чадавхийг нэмэгдүүлэх;

3/ үндэсний соёл иргэншил, оюуны өв уламжлал, чадавхийг хамгаалан хөгжүүлэх;

4/ Монгол Улсын байгалийн баялгаа эзэмших бүрэн эрх, экологийн аюулгүй байдлыг хангах;

5/ гадаад орон, олон улсын байгууллагатай төр, засгийн дээд хэмжээний хэлэлцээрийн үед баримтлах чиглэл, гадаад орон, олон улсын байгууллагад тодорхой асуудлаар төр, засгийн дээд хэмжээнд байр сууриа илэрхийлэхдээ төрийн гадаад бодлогод нийцүүлж зөвлөлдөн тогтох;

*/Энэ заалтыг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

6/ төрийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлж, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, улс төрийн гадаад нөхцөл байдлыг харгалзан төрийн цэргийн бодлогын үндсийн талаарх саналыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

*[/Энэ заалтыг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/]*

7/ Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс олон улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, цэрэг, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодорхойлох.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## Зөвлөлийн бүрэлдэхүүн, бүтэц, бүрэн эрх

### 5 дугаар зүйл. Зөвлөлийн тэргүүн, гишүүд, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүрэг

*[/Энэ зүйлийн нэрийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/]*

1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Зөвлөлийн гишүүн байна.

/Энэ хэсэгт 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Хууль тогтоомжид заасан үндэслэлээр Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал зохих өөрчлөлт оруулж болно.

/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3. Зөвлөлийн тэргүүн нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч байна. Зөвлөлийн тэргүүн нь Зөвлөлийн ажлыг бүхэлд нь удирдаж, дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Зөвлөлийн хуралдаанд хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

2/ Зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх саналыг Улсын Их Хуралд оруулах;

3/ төрийн гадаад, дотоод бодлогыг хэрэгжүүлэхэд Зөвлөлийг төлөөлөх;

4/ Зөвлөлийн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

5/хуульд заасан бусад бүрэн эрх.

/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/

4. Зөвлөлийн гишүүн нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ үндэсний аюулгүй байдал болон төрийн гадаад, дотоод бодлогын нэгдмэл байдлыг хангах үүднээс улс орны төр, нийгмийн амьдралд дүн шинжилгээ хийлгэж, авах шаардлагатай арга хэмжээний талаар санал боловсруулан Зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

2/ Зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох байгууллага, түүний дотор үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагын ажилтай танилцах, чиглэл зөвлөлгөө өгөх;

3/ Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг эрхэлсэн ажлын хүрээнд зохион байгуулах;

4/ Зөвлөлийн ажлын хэсэгт чиглэл, үүрэг, даалгавар өгөх;

5/ өөрийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахын өмнө Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж байх;

6/ хуульд заасан бусад бүрэн эрх.

/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/

**6 дугаар зүйл. Зөвлөлийн зохион байгуулалтын бүтэц**

1. Зөвлөл нь энгийн бүтэцтэй байх бөгөөд түүнд Зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга, зөвлөх, илтгэгч, шинжээчийн хэсэг хамаарна.

2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн үндсэн чиг үүрэгт хамаарах асуудлаар судалгаа хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах, шийдвэрийн үндэслэлийг боловсруулах, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж, Зөвлөлийн гишүүд бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь тусалж, тэднийг үндэсний аюулгүй байдлын талаарх судалгаа, мэдээллээр хангах дотоод ажлыг эрхэлнэ. Зөвлөлийн нарийн бичгийн дарга уг албан тушаалыг хаших хугацаанд түүний улс төрийн намын гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ. Зөвлөлийн нарийн бичгийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.

*/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

3. Улсын Их Хурлын дэд дарга, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ахлагч, тагнуулын төв байгууллагын дарга нар зөвлөлийн хуралдаанд зөвлөх эрхтэй оролцоно.

*/Энэ хэсэгт 1998 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

*/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

*/Энэ хэсэгт 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

4. Монгол Улсын Засгийн газрын гишүүн, тусгай газар, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга нар Зөвлөлийн илтгэгч байх бөгөөд тэдгээр нь тус тусын хариуцсан салбар, хүрээнд үндэсний язгуур ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг судалж зохих илтгэл, санал, шийдвэрийн төслийг боловсруулан Зөвлөлд оруулж, гарсан шийдвэрийг эрхэлсэн салбар, хүрээндээ хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

*/Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

5. Зөвлөлийн шинжээчээр өндөр мэргэшлийн эрдэмтэн, мэргэжилтнийг орон тооны ба орон тооны бус журмаар томилон ажиллуулна. Тэдгээр нь үндэсний аюулгүй байдлыг хангах тодорхой асуудлаар болон Зөвлөлийн шийдвэрийн төслийн талаар шинжилгээ, судалгаа хийж, мэргэжлийн дүгнэлт гаргаж, түүний үндэслэлийг хариуцна. Зөвлөлийн шинжээчийг Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.

6. Зөвлөл нь үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд онцгой ач холбогдол бүхий чиглэл, дотоодын болон олон улсын үйл явдал зэрэг шаардлагатай гэж үзсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах, судалгаа явуулах эрдэм шинжилгээний бие даасан нэгжтэй байж болно.

*/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

**7 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх**

1. Зөвлөл нь энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

1/ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хуулийн биелэлтийн явцыг хэлэлцэж дүгнэлт гаргах;

2/ үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн дотоод, гадаад, батлан хамгаалах бодлогын үндсийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон онц чухал асуудлыг шийдвэрлэх чиглэл өгөх;

3/ зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох байгууллагад шалган танилцаж, тэдгээрийн удирдагчдын илтгэл, мэдээллийг сонсож, зөвлөмж, заалт, чиглэл өгөх;

4/ үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагад эрх хэмжээнийхээ дагуу үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих;

5/ даалгавар, зөвлөмж болон гэрээний үндсэн дээр холбогдох байгууллагаас шаардлагатай судалгаа, мэдээ гаргуулан авах, үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд онцгой ач холбогдол бүхий асуудлаар стратегийн судалгаа хийх ажлыг ивээл, хяналтдаа авах, эрдэм шинжилгээний төслийн хэлбэрээр санхүүжүүлэх.

*/Энэ заалтад 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

2. Зөвлөлд бусад бүрэн эрхийг Улсын Их Хурал олгож болно.

**$7^1$ дүгээр зүйл. Зөвлөлийн онцгой бүрэн эрх**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсны улмаас онц байдал зарлах тухай шийдвэр буюу Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн онц байдал үргэлжлэх хугацаанд Зөвлөл онц байдлыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах онцгой чиг үүрэг гүйцэтгэнэ. Энэ чиг үүргийн дагуу Зөвлөлийн хэрэгжүүлэх онцгой бүрэн эрхийг Онц байдлын тухай хуулиар тогтооно.

*/Энэ зүйлийг 1995 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн хуулиар нэмсэн/*

**8 дугаар зүйл. Зөвлөлийн ажлын зохион байгуулалт, аппарат**

1. Зөвлөл бүрэн эрхийнхээ асуудлыг Зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэнэ. Хуралдаанд Зөвлөлийн зөвлөх, илтгэгч, шинжээч нар зөвлөх эрхтэй оролцоно.

2. Зөвлөлийн хуралдааны болон ажлын дэгийг Зөвлөлийн шийдвэрээр тогтооно.

3. Зөвлөл нь ажлын албатай байна.

*/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

4. Зөвлөлийн ажлын албаны болон үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

*/Энэ хэсэгт 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

5. Зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна.

*/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/*

**9 дүгээр зүйл. Зөвлөлийн шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх**

1. Зөвлөл нь хэлэлцэн зөвшилцөлд хүрсэн асуудлаар шийдвэр гаргах бөгөөд тэр нь зөвлөмжийн шинж чанартай байна.

2. Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн түүний хүрээнд төрийн дээд, төв байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ дагуу холбогдох шийдвэр боловсруулан гаргаж зохих журмаар хэрэгжүүлнэ.

3. Байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ, түүний үр дүнг тогтоосон хугацаанд хариу мэдээлэх үүрэгтэй.

**10 дугаар зүйл. Зөвлөлийг мэдээллээр хангах тогтолцоо**

1. Төрийн холбогдох байгууллагууд Зөвлөлийг шаардагдах мэдээллээр тогтоосон журмын дагуу хангана. Энэхүү журмыг Зөвлөлийн шийдвэрийн үндсэн дээр Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

2. Зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийн нэгдсэн сантай байна. Мэдээллийн нэгдсэн сан нь төрийн холбогдох байгууллагууд, иргэд, гадаадын эх сурвалжаас ирүүлсэн бүх төрлийн мэдээллээс бүрдэнэ.

*/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

3. Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц, зохион байгуулалт, бүрдүүлэлт, ашиглалтын журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. Зөвлөлийн дэргэдэх мэдээллийн нэгдсэн сан нь төрийн нууцад хамаарах бөгөөд тусгай хамгаалалтад байна.

*/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/*

4. Зөвлөлийн ажлын алба нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх бүтэцтэй байна.

*/Энэ хэсгийг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/*

**МОНГОЛ УЛСЫН БАГА ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ**

---

**МОНГОЛ УЛСЫН БАГА ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б. ЧИМИД**

---